

Даатгалын компаниудын хөрөнгийн санхүүжилтийн шинжилгээ

Analysis of Asset Financing in Insurance Companies

Л. Баасандорж¹

Хураангуй

Энэхүү судалгаа нь Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй Мандал даатгал ХК, Ард даатгал ХК, Бодь даатгал ХК-ийн 2020-2022 оны санхүүгийн тайлангийн мэдээлэлд тулгуурлан эдгээр компанийн хөрөнгийн бүтэц, санхүүжилтийн түвшинг Савицкаягийн загварын дагуу шинжилсэн. Судалгааны үр дүнгээс харахад дээрх компаниудын хөрөнгийн санхүүжилтийн бүтэц нь В түвшинд байгаа бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг хангаж байгаа ч урт хугацаат өрийг нэмэгдүүлэх замаар бүтцийг А түвшинд хүргэх боломжтой болохыг харууллаа. Энэхүү судалгаа нь хөрөнгийн санхүүжилтийн оновчлолын талаар зөвлөмж гаргаж, даатгалын салбарын санхүүгийн удирдлагын үр ашигт хувь нэмэр оруулна.

Түлхүүр үгс: хөрөнгийн бүтэц, санхүүжилтийн түвшин, даатгалын компани, Савицкаягийн загвар, санхүүгийн тогтвортой байдал

Abstract

This study analyzes the capital structure and financing levels of three insurance companies listed on the Mongolian Stock Exchange's Tier I: Mandal Insurance JSC, Ard Insurance JSC, and Bodi Insurance JSC, based on their financial reports from 2020-2022. Using Savitskaya's model, the study finds that the capital structure of these companies is currently at the B level, ensuring financial stability. However, the findings suggest that increasing long-term liabilities can potentially elevate the structure to the A level. This research provides recommendations for optimizing capital structure and contributes to improving the financial management efficiency of the insurance sector.

Keywords: capital structure, financing levels, insurance companies, Savitskaya's model, financial stability

¹ МУИС-ийн Бизнесийн Сургууль, Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн докторант
E-mail: baasandorj@num.edu.mn

1. Удиртгал

Даатгалын салбар нь санхүүгийн зах зээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хөрөнгийн зохистой удирдлага, санхүүжилтийн оновчтой бүтэц нь компанийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үндэс болдог. Хөрөнгийн санхүүжилтийн бүтэц нь компанийн хөрөнгийг санхүүжүүлэхэд ашиглаж буй эх үүсвэрүүдийн харьцааг илэрхийлэх бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагааны тогтвортой байдал, төлбөрийн чадвар, ашигт ажиллагаанд шууд нөлөөлдөг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил эрчимтэй явагдаж, даатгалын салбарын компаниудын үйл ажиллагааны хүрээ өргөжин тэлж байна. Гэвч эдгээр компаниудын хөрөнгийн санхүүжилтийн бүтэц, хөрөнгийн удирдлагын үр ашигт ажиллагааг системтэй үнэлэх судалгаа хязгаарлагдмал байна. Санхүүжилтийн бүтэц дэх богино хугацаат өрийн өндөр хувь хэмжээ нь компаниудын төлбөрийн чадварт эрсдэл учруулж болох ч хөрөнгийн бүтцийн оновчлол нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах чухал арга зам байж болохыг олон улсын судалгаанууд харуулж байна.

Энэхүү судалгааны зорилго нь Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй Мандал даатгал ХК (цаашид МД ХК гэх), Ард даатгал ХК (цаашид АД ХК гэх), Бодь даатгал ХК (цаашид БД ХК гэх) гэсэн гурван компанийн 2020-2022 оны санхүүгийн тайлангийн мэдээлэлд тулгуурлан эдгээр компанийн хөрөнгийн бүтэц, санхүүжилтийн түвшинг үнэлж, ОХУ-ын эрдэмтэн Г.В.Савицкаягийн боловсруулсан загварын дагуу санхүүжилтийн бүтцийг сайжруулах

боломжийг тодорхойлох явдал юм.

Судалгаанд дараах асуултуудыг дэвшүүлэн судалсан болно:

- Даатгалын компаниудын хөрөнгийн бүтэц, санхүүжилтийн түвшин ямар байна вэ?
- Санхүүжилтийн бүтэц нь Савицкаягийн В болон А түвшний нормтой хэрхэн уялдаж байна вэ?
- Санхүүжилтийн бүтэц А түвшинд хүрэхэд ямар өөрчлөлт шаардлагатай вэ?

Энэхүү судалгаа нь хөрөнгийн санхүүжилтийн оновчлолын талаар бодлого боловсруулахад практик зөвлөмж өгөхөөс гадна Монголын даатгалын салбарын санхүүгийн удирдлагыг сайжруулахад чухал хувь нэмэр оруулах юм.

Энэхүү өгүүллийн үлдсэн хэсгүүд нь дараах бүтэцтэй байна. Хоёр дахь хэсэгт судалгааны онолын үндэслэл, өмнөх судалгааны тоймыг өгүүлнэ. Гуравдугаар хэсэгт судалгааны арга зүйг тайлбарлаж, дөрөвдүгээр хэсэгт судалгааны үр дүнг хэлэлцэнэ. Эцэст нь, дүгнэлт ба санал бүхий хэсэгт судалгааны гол үр дүнг нэгтгэн дүгнэх болно.

2. Онолын үндэслэл ба судлагдсан байдал

Хөрөнгийн санхүүжилтийн онол нь компаниудын санхүүгийн эх үүсвэрийг оновчтой хуваарилах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд чиглэсэн судалгааны чухал хэсэг юм. Санхүүжилтийн бүтцийн онолын үндэс нь Модильяни-Миллерийн теорем (1958) дээр тулгуурлан компаниудын өр болон өөрийн хөрөнгийн харьцаа нь компанийн үнэлгээ болон үйл ажиллагааны эрсдэлд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарладаг. Уг теорем нь капиталын зах зээлийн төгс нөхцөлд санхүүжилтийн

бүтцийн нөлөө хязгаарлагдмал гэж үзсэн боловч бодит байдалд зах зээлийн хязгаарлалтууд, татварын бодлого, агентлагийн зардал зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг болохыг олон судалгаанд дурдсан байдаг.

Г.В.Савицкаягийн (2011) боловсруулсан хөрөнгийн санхүүжилтийн бүтцийн загвар нь хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тогтмол ба хувьсах хэсэг гэж ангилах бөгөөд эдгээрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг оновчтой тодорхойлох аргачлалыг санал болгодог. Энэхүү загвар нь хөрөнгийн санхүүжилтийн түвшинг “шинэлэг” (А), “дунд зэрэг” (В), “хуучинсаг” (С) гэсэн гурван ангиллаар үнэлдэг. Судалгааны аргачлал нь санхүүжилтийн бүтэц, хөрөнгийн удирдлагыг үр дүнтэй үнэлэх боломжийг олгодог бөгөөд энэхүү загварыг даатгалын салбарт хэрэглэсэн тохиолдлууд бага судлагдсан байна.

Хөрөнгийн санхүүжилтийн талаар олон улсад хийгдсэн судалгаанууд нь хөрөнгийн бүтцийн болон санхүүжилтийн удирдлагын талаарх онолын болон эмпирик судалгаанд чухал хувь нэмэр оруулсан байдаг. Тухайлбал:

Nissim (2010) нь Колумбын бизнесийн сургуулийн хүрээнд даатгалын компаниудын санхүүжилтийн удирдлагад эмпирик шинжилгээ хийж, хөрөнгийн бүтцийн ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөг судалсан.

Jaishi (2020) Непал улсын даатгалын салбарын санхүүгийн үзүүлэлтэд хөрөнгийн бүтцийн нөлөөллийг үнэлж, санхүүжилтийн оновчлолыг чухалчилсан байна.

Ahmed нар (2010) Пакистаны даатгалын компаниудын капиталын бүтцэд үзүүлэх

хүчин зүйлийг олон хувьсагчийн OLS регрессийн шинжилгээгээр судалж, санхүүгийн хөшүүргийн ашиглалтыг харуулсан.

Ayuba нар (2019) нь Нигер улсын даатгалын компаниудын хөрөнгийн санхүүжилтийн бүтцийн загвар болон ашигт ажиллагаанд үзүүлэх нөлөөг тодорхойлсон.

Монгол Улсад хөрөнгийн санхүүжилтийн талаар цөөн тооны судалгаа хийгдсэн бөгөөд даатгалын салбарт тусгайлан чиглэсэн судалгаа ховор байна. МД ХК, АД ХК, БД ХК-ийн санхүүгийн тайлангийн мэдээллийг ашиглан Савицкаягийн загварын дагуу хөрөнгийн санхүүжилтийн оновчлолын талаар судалгаа хийх оролдлого нь онолын болон практик ач холбогдолтой гэж үзэж байна.

3. Судалгааны арга зүй

Энэхүү судалгаанд Монголын хөрөнгийн биржийн хувьцааны I ангилалд бүртгэлтэй, даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг МД ХК, АД ХК, БД ХК гэсэн гурван компанийн 2020-2022 оны санхүүгийн тайлангийн мэдээлэлд тулгуурлан шинжилгээ хийсэн. Судалгааны зорилго нь эдгээр компанийн хөрөнгийн бүтцийн өнөөгийн байдал, хөрөнгийн санхүүжилтийн харьцааг тодорхойлох, түүнчлэн санхүүжилтийн бүтэц В түвшнээс А түвшинд хүрэх боломжийг онолын загварын дагуу тооцоолох явдал юм.

Судалгаанд ОХУ-ын эдийн засагч Г.В.Савицкаягийн боловсруулсан хөрөнгө, хөрөнгийн санхүүжилтийн бүтцийн онолын загварыг ашигласан. Савицкаягийн загварт хөрөнгийг эргэлтийн бус хөрөнгө (ЭБХ), эргэлтийн хөрөнгийн тогтмол хэсэг (ЭХТХ), эргэлтийн хөрөнгийн хувьсах хэсэг (ЭХХХ) гэж ангилж, эдгээрийг санхүүжүүлэх

Хүснэгт 1. Савицкаягийн хөрөнгө, хөрөнгийн санхүүжилтийн бүтцийн загвар

Хөрөнгийн төрөл	Хөрөнгийг санхүүжүүлэх боломж		
	Шинэлэг (А)	Дунд зэрэг (В)	Хуучинсаг (С)
Эргэлтийн бус хөрөнгө	40% УХӨТ+60% ӨК	20% УХӨТ+80% ӨК	10% УХӨТ+90% ӨК
Эргэлтийн хөрөнгийн тогтмол хэсэг	50% УХӨТ+50% ӨК	25% УХӨТ+75% ӨК	100% ӨК
Эргэлтийн хөрөнгийн хувьсах хэсэг	100% БХӨТ	100% БХӨТ	50% ӨК 50% БХӨТ

Эх сурвалж: Наранчимэг (2011)

Хүснэгт 2. Даатгалын компанийн хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц

№	Хөрөнгө	№	Хөрөнгийн санхүүжилт
1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2.1.1	Даатгалын өглөг
1.2	Даатгалын авлага	2.1.2	Бусад санхүүгийн өр төлбөр
1.3	Бусад санхүүгийн хөрөнгө	2.1.3	Бусад санхүүгийн бус өр төлбөр
1.4	Бусад санхүүгийн бус хөрөнгө	2.1.4	Хоёрдогч өглөг, хүү
1.5	Хөрөнгө оруулалт	2.1.5	Давуу эрхтэй хувьцаа (хөрвөхгүй)
1.6	Даатгалын хөрөнгө	2.1.6	Орлогд тооцоогүй хураамжийн нөөц
1.7	Үндсэн хөрөнгө	2.1.7	Нөхөн төлбөрийн нөөц сан
1.8	Биет бус хөрөнгө	2.2	Эзэмшигчийн өмч
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		

Эх сурвалж: Сангийн Яам (2022)

тохиромжтой эх үүсвэрийг дараах байдлаар тодорхойлдог (Хүснэгт 1).

Даатгалын компанийн хувьд хөрөнгө болон хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийн бүтэц нь бусад компанийн бүтцээс ялгаатай байдаг (Хүснэгт 2). Даатгалын компанийн хөрөнгийн болон хөрөнгийн санхүүжилтийн онцлогийг тодруулахын тулд 2020-2022 оны санхүүгийн үзүүлэлтүүдийг дундажлан тооцож, үндсэн гурван компанийн хөрөнгийн бүтэц, хөрөнгийн эх үүсвэрийн хувь хэмжээг тодорхойлсон. Дараа нь тухайн үзүүлэлтүүдийг Савицкаягийн загварын В ангилалд харьцуулж, дүгнэлт гаргасан.

Үүний дараа хөрөнгийн бүтэц А түвшинд хүрэхийн тулд шаардлагатай өөрчлөлтийг тооцоолсон. Үүнд:

- Хөрөнгийг эргэлтийн бус, тогтмол ба хувьсах хэсэгт ангилах;
- Хөрөнгийн дундаж бүтэц болон

санхүүжилтийн эх үүсвэрийн харьцааг бодит мэдээллээс тооцоолох;

- Савицкаягийн “шинэлэг” нормд тулгуурлан шинэчлэх хувилбаруудыг загварчлах.

Ингэснээр Хүснэгт 3-5 хүснэгтүүдэд харгалзах шинэчилсэн санхүүжилтийн бүтцийн хувилбаруудыг харуулсан болно.

4. Судалгааны үр дүн

4.1. МД ХК-ийн санхүүжилтийн бүтэц

2020-2022 оны хугацаанд тус компанийн нийт хөрөнгийн 97 орчим хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж, эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь дунджаар 3% байв. Эргэлтийн хөрөнгийн дийлэнхийг хөрөнгө оруулалт, даатгалын хөрөнгө болон авлага эзэлж байжээ. Тус компанийн хөрөнгийн бүтэц, жилийн өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 6 болон Хүснэгт 7-д үзүүлсэн болно. Хөрөнгийн санхүүжилтийн эх үүсвэрийг авч үзвэл, богино хугацаат өр 46.5%, урт

Хүснэгт 3. МД ХК-ийн санхүүжилтийн зохимжтой бүтцийн талаарх тооцоолол, санал

Хөрөнгийн төрөл	Норм	Хөрөнгийн санхүүжүүлэх боломж (А)	Санхүүжилтийн хувь оролцооны тооцоолол	Өнөөгийн санхүүжилтийн бүтэц	Шинэчилсэн санхүүжилтийн бүтэц
ЭБХ	2.9%	0.4 - УХӨТ	1.2% - УХӨТ	ӨК - 42.6% УХӨТ - 10.9% БХӨТ - 46.5%	ӨК - 27.0% УХӨТ - 26.4% БХӨТ - 46.5%
		0.6 - ӨК	1.7% - ӨК		
ЭХТХ	50.6%	0.5 - УХӨТ	25.3% - УХӨТ		
		0.5 - ӨК	25.3% - ӨК		
ЭХХХ	46.5%	1.0 - БХӨТ	46.5% - БХӨТ		

Хүснэгт 4. АД ХК-ийн санхүүжилтийн зохимжтой бүтцийн талаарх тооцоолол, санал

Хөрөнгийн төрөл	Норм	Хөрөнгийн санхүүжүүлэх боломж (А)	Санхүүжилтийн хувь оролцооны тооцоолол	Өнөөгийн санхүүжилтийн бүтэц	Шинэчилсэн санхүүжилтийн бүтэц
ЭБХ	5.2%	0.4 - УХӨТ	2.1% - УХӨТ	ӨК - 48.8% УХӨТ - 9.8% БХӨТ - 41.4%	ӨК - 29.8% УХӨТ - 28.8% БХӨТ - 41.4%
		0.6 - ӨК	3.1% - ӨК		
ЭХТХ	53.4%	0.5 - УХӨТ	26.7% - УХӨТ		
		0.5 - ӨК	26.7% - ӨК		
ЭХХХ	41.4%	1.0 - БХӨТ	41.4% - БХӨТ		

Хүснэгт 5. БД ХК-ийн санхүүжилтийн зохимжтой бүтцийн талаарх тооцоолол, санал

Хөрөнгийн төрөл	Норм	Хөрөнгийн санхүүжүүлэх боломж (А)	Санхүүжилтийн хувь оролцооны тооцоолол	Өнөөгийн санхүүжилтийн бүтэц	Шинэчилсэн санхүүжилтийн бүтэц
ЭБХ	4.1%	0.4 - УХӨТ	1.6% - УХӨТ	ӨК - 33.2% УХӨТ - 10.2% БХӨТ - 56.5%	ӨК - 22.1% УХӨТ - 21.3% БХӨТ - 56.5%
		0.6 - ӨК	2.5% - ӨК		
ЭХТХ	39.4%	0.5 - УХӨТ	19.7% - УХӨТ		
		0.5 - ӨК	19.7% - ӨК		
ЭХХХ	56.5%	1.0 - БХӨТ	56.5% - БХӨТ		

Хүснэгт 6. МД ХК-ийн хөрөнгө, хөрөнгийн санхүүжилтийн байдал, мян.төг-өөр

	2020	2021	2022	Дундаж
ЭХ	53,528,164.50	57,269,132.04	71,280,085.50	60,692,460.68
ЭБХ	1,627,572.00	1,562,381.28	2,275,749.80	1,821,901.03
НХ	55,155,736.50	58,831,513.32	73,555,835.30	62,514,361.71
БХӨ	26,079,788.20	24,015,903.66	37,859,369.10	29,318,353.65
УХӨТ	6,421,757.40	7,043,737.18	6,595,364.70	6,686,953.09
ЭӨ	22,654,190.90	27,771,872.48	29,101,101.50	26,509,054.96
НЭҮ	55,155,736.50	58,831,513.32	73,555,835.30	62,514,361.71

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

хугацаат өр 10.9%, өөрийн хөрөнгө 42.6%-ийг дунджаар эзэлж байна (Хүснэгт 8).

4.2. АД ХК-ийн санхүүжилтийн бүтэц

АД ХК-ийн нийт хөрөнгийн дийлэнхийг мөн эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бөгөөд 2022 онд уг хувь 98.9%-д хүрсэн байна. Харин эргэлтийн бус хөрөнгө маш бага буюу 1.1% байв. Хөрөнгийн санхүүжилтийн хувьд тус компани богино хугацаат өрийг

41.4%, урт хугацаат өрийг 9.8%, өөрийн хөрөнгийг 48.8%-ийн харьцаатайгаар ашиглаж байна. Хөрөнгийн бүтцийн санхүүжилт нь Савицкаягийн В түвшинд орж байгаа бөгөөд хувьсах хэсгийг 100% богино хугацаат өрөөр, тогтмол хэсгийн 81.5%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа нь санхүүгийн хөшүүргийг хянаж буйг харуулна (Хүснэгт 9).

Хүснэгт 7. МД ХК-ийн хөрөнгийн бүтэц, хувиар

Үзүүлэлт	2020	2021	2022	Дундаж
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	4.0%	6.3%	1.4%	3.9%
Даатгалын авлагын дүн	10.2%	12.8%	11.6%	11.5%
Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	0.0%	0.1%	0.1%	0.1%
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	1.0%	1.5%	2.0%	1.5%
Хөрөнгө оруулалтын дүн	56.8%	59.1%	52.8%	56.3%
Даатгалын хөрөнгийн дүн	24.9%	17.6%	28.9%	23.8%
Үндсэн хөрөнгө (Цэвэр)	2.7%	2.2%	2.9%	2.6%
Биет бус хөрөнгө (Цэвэр)	0.3%	0.4%	0.2%	0.3%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	100.0%	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 8. МД ХК-ийн хөрөнгийн эх үүсвэрийн бүтэц, хувиар

Үзүүлэлт	2020	2021	2022	Дундаж
Даатгалын өглөгийн дүн	5.3%	7.0%	8.6%	7.0%
Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	0.0%	0.0%	0.3%	0.1%
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн	3.2%	3.5%	2.3%	3.0%
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	38.7%	30.3%	40.2%	36.4%
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	11.6%	12.0%	9.0%	10.9%
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	58.9%	52.8%	60.4%	57.4%
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	41.1%	47.2%	39.6%	42.6%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	100.0%	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 9. АД ХК-ийн хөрөнгийн санхүүжилтийн бүтэц, хувиар

Хөрөнгө	2020	2021	2022	Дундаж	Санхүүжилт	2020	2021	2022	Дундаж
ЭХХХ	42.9%	37.4%	43.9%	41.4%	БХӨ	100.0%	100.0%	100.0%	100.0%
ЭХТХ	48.6%	56.6%	54.9%	53.4%	УХӨ	22.3%	17.3%	15.9%	18.5%
					ЭӨ	77.7%	82.7%	84.1%	81.5%
ЭБХ	8.4%	6.0%	1.1%	5.2%	ЭӨ	100.0%	100.0%	100.0%	100.0%

4.3. БД ХК-ийн санхүүжилтийн бүтэц

БД ХК-ийн нийт хөрөнгийн 95-96 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байв. Эргэлтийн хөрөнгийн дийлэнх хэсгийг хөрөнгө оруулалт, даатгалын хөрөнгө, авлага бүрдүүлж байна (Хүснэгт 10-11). Санхүүжилтийн бүтэц дунджаар 56.5% богино хугацаат өр, 9.9% урт хугацаат өр, 33.2% өөрийн хөрөнгөөс бүрдэж байна (Хүснэгт 12).

4.4. Харьцуулсан дүн шинжилгээ

Гурван компанийн хувьд хөрөнгийн бүтэц ижил төстэй байгаа бөгөөд нийт хөрөнгийн 95-97%-ийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж, эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь бага байна. Санхүүжилтийн бүтэц нь

нийтлэг байдлаар В түвшинд хамаарах ба өөрийн хөрөнгийн оролцоо 33%-49%, өрийн оролцоо 51%-67% байна. Энэ нь даатгалын компаниудын санхүүгийн хөшүүргийг хязгаарлагдмал түвшинд хадгалж, тогтвортой байдлыг эрхэмлэж байгааг илтгэнэ.

Энэхүү судалгааны үр дүнгээс харвал судалгаанд хамрагдсан компаниудын хөрөнгийн бүтэц, санхүүжилтийн түвшин нь дундаж (В) түвшинд байгаа бөгөөд санхүүгийн хөшүүрэг, тогтвортой байдлыг хангаж байна. Энэ нь даатгалын салбарын онцлогтой нийцэж буйг харуулж байгаа ч, сайжруулалтын боломж байгааг харгалзан дүгнэлт хэсэгт санал болгож байна.

Хүснэгт 10. БД ХК-ийн хөрөнгө, хөрөнгийн санхүүжилтийн байдал, мян.төг-өөр

	2020	2021	2022	Дундаж
ЭХ	31,213,283.50	43,314,481.80	30,292,309.10	34,940,024.80
ЭБХ	1,530,145.50	1,459,854.50	1,377,029.40	1,455,676.47
НХ	32,743,429.00	44,774,336.30	31,669,338.50	36,395,701.27
БХӨ	15,919,439.70	28,313,653.90	18,288,130.50	20,840,408.03
УХӨТ	3,391,792.70	3,183,977.80	4,186,344.00	3,587,371.50
ЭӨ	13,432,196.60	13,276,704.60	9,194,864.00	11,967,921.73
НЭҮ	32,743,429.00	44,774,336.30	31,669,338.50	36,395,701.27

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Хүснэгт 11. БД ХК-ийн хөрөнгийн бүтэц, хувиар

Үзүүлэлт	2020	2021	2022	Дундаж
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	1.1%	2.4%	2.7%	2.1%
Даатгалын авлагын дүн	11.7%	16.8%	15.8%	14.8%
Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	10.6%	6.4%	6.1%	7.7%
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	3.4%	3.7%	6.1%	4.4%
Хөрөнгө оруулалтын дүн	41.9%	29.6%	46.7%	39.4%
Даатгалын хөрөнгийн дүн	26.6%	37.7%	18.2%	27.5%
Үндсэн хөрөнгө /Цэвэр/	4.3%	3.1%	4.2%	3.9%
Биет бус хөрөнгө /Цэвэр/	0.3%	0.2%	0.2%	0.2%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	100.0%	100.0%	100.0%	100.0%

Хүснэгт 12. БД ХК-ийн хөрөнгийн эх үүсвэрийн бүтэц, хувиар

Үзүүлэлт	2020	2021	2022	Дундаж
Даатгалын өглөгийн дүн	3.2%	7.2%	5.4%	5.3%
Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	2.4%	2.2%	1.2%	1.9%
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн	2.3%	2.1%	3.0%	2.5%
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	40.7%	51.8%	48.2%	46.9%
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	10.4%	7.1%	13.2%	10.2%
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	59.0%	70.3%	71.0%	66.8%
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	41.0%	29.7%	29.0%	33.2%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	100.0%	100.0%	100.0%	100.0%

5. Дүгнэлт

Энэхүү судалгаа нь Монголын хөрөнгийн биржийн хувьцааны I ангилалд бүртгэлтэй гурван даатгалын компанийн 2020–2022 оны санхүүгийн тайлангийн мэдээлэлд үндэслэн хөрөнгийн бүтэц, санхүүжилтийн түвшнийг Савицкаягийн загварын дагуу шинжилсэн. Судалгааны үндсэн үр дүнг дараах байдлаар дүгнэв.

Хөрөнгийн бүтэц

Судалгаанд хамрагдсан компаниудын нийт хөрөнгийн 95-97%-ийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байгаа нь даатгалын

салбарын онцлогт нийцэж байна. Эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь бага байгаа нь эдгээр компаниудын хөрөнгийн хуваарилалт хөрвөх чадвар өндөртэй, богино хугацаанд ашиглах боломжтой хөрөнгөд төвлөрч байгааг харуулна.

Санхүүжилтийн бүтэц

Компаниудын санхүүжилтийн эх үүсвэрийн хувьд 33-49%-ийг өөрийн хөрөнгө, 51-67%-ийг өр бүрдүүлж байна. Энэ нь дундаж (В) түвшинд байгааг харуулж байгаа бөгөөд санхүүгийн тогтвортой байдлыг харьцангуй хангаж байна.

Тогтвортой байдал ба хөшүүрэг

Санхүүжилтийн бүтцээс харахад компаниуд богино хугацаат өрийг түлхүү ашиглаж байгаа нь төлбөрийн чадварын эрсдэл үүсгэх боломжтой боловч компанийн үйл ажиллагааны хяналттай байдлыг баталгаажуулж байна.

Судалгааны үр дүнд үндэслэн дараах саналуудыг дэвшүүлж байна.

Санхүүжилтийн бүтцийг сайжруулах

Урьдчилан тооцоолсон дүнгээс харахад компаниуд санхүүжилтийн бүтэцдээ урт хугацаат өрийг нэмэгдүүлэх замаар санхүүгийн хөшүүргийг оновчтой болгох боломжтой. Энэ нь зардлыг бууруулж, санхүүгийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Эх үүсвэрийн олон төрөлт

Санхүүгийн нөөцөө үр дүнтэй ашиглах, хөрөнгийн бүтцийг оновчтой болгохын тулд компаниуд санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх стратегийг баримтлах шаардлагатай.

Эдийн засгийн нөхцөл байдалд дасан зохицох

Даатгалын салбарын онцлогийг харгалзан эдийн засгийн өөрчлөлт, санхүүгийн эрсдэлийг хязгаарлах бодлогыг хэрэгжүүлж, хөрөнгийн бүтцээ тогтвортой хадгалах арга хэмжээ авах нь чухал.

Энэхүү судалгааны дүн нь хөрөнгийн санхүүжилтийн бүтцийн оновчлолын талаар бодлого боловсруулахад ашиглаж болохоор байна. Цаашид даатгалын салбарт чиглэсэн судалгааны арга зүйг өргөжүүлж, олон улсын хэмжээнд харьцуулсан судалгаа хийх боломжтой.

Ашигласан материал

- Ahmed, N., Ahmed, Z., & Ahmed, I. (2010). Determinants of Capital Structure: A Case of Life Insurance Sector of Pakistan. *European Journal of Economics, Finance and Administrative Sciences*, 24, 7-12.
- Ayuba, H., Bambale, A. J., Ibrahim, M. A., & Sulaiman, S. A. (2019). Effects of Financial Performance, Capital Structure and Firm Size on Firms' Value of Insurance Companies in Nigeria. *Journal of Finance, Accounting and Management*, 10(1), 57-74.
- Bashir, M. K., Ayyad, K. W. & Abu Jumaiza, A. R. (2015). *Analyzing and Evaluation of Financial Performance for Insurance Companies (Study Case Trust Insurance Company)*. Egypt.
- Eladly, S. M. (2021). The Impact of the Financial Performance on Capital Structure of Insurance Industry in Egypt. *International Business Research*, 14(7), 103-114.
- Graham, J. R. & Harvey, C. R. (2001). The Theory and Practice of Corporate Finance: Evidence from the Field. *Journal of Financial Economics*, 60(2-3), 187-243.
- Jaishi, B. (2020). Capital Structure and its Impact on Financial Performance in Insurance Companies of Nepal. *The Journal or Nepalese Business Studies*, 13(1), 89-106.
- Kulustayeva, A., Jondelbayeva, A., Nurmagambetova, A., Dossayeva, A., & Bikteubayeva, A. (2020). Financial Data Reporting Analysis of the Factors Influencing on Profitability for Insurance Companies. *Journal of Entrepreneurship and Sustainability*, 7(3), 2394-2406.

- Nissim, D. (2010). *Analysis and Valuation of Insurance Companies*. New York.
- Sigidov, Y. I., Rybyantseva, M. S., Adamenko, A. A., & Yarushkina, E. A. (2016). Methodological Aspects of Depreciation as an Economic Category. *International Journal of Economics and Financial Issues*, 6(1S), 88-95.
- Баасандорж, Л. (2018). Хөрөнгийн санхүүжилтийн бүтцийг санхүүгийн зохистой харьцаагаар удирдах нь. *Proceedings for International Conference on Accounting, Auditing, and Valuation, Улаанбаатар*, 259-267.
- Баасандорж, Л. (2019). Хөрөнгийн санхүүжилтийн удирдлагын тухай ойлголт, суурь үзэл баримтлалууд. *Journal of Accounting Theory and Practice*, 3(1), 33-43.
- Ковалев, В. (2006). *Введение в финансовый менеджмент*. Москва.
- Крылов, Э. В., Власова, В. М., & Журавкова, И. В. (2003). *Анализ эффективности инвестиционной и инновационной деятельности предприятия*. Москва.
- Кузнецов, Н. В. (2016). *Развитие методологии управления финансовым обеспечением электэнергетических компаний*. Москва.
- Моломжамц, Д. (2000). *Санхүүгийн шинжилгээ*. Улаанбаатар.
- Моляков, Д. С. (2000). *Финансы предприятий отраслей народного хозяйства*. Москва.
- МУИС-ийн Эрдэнэт сургууль (2014). *Санхүү эдийн засгийн шинжилгээ*. Эрдэнэт.
- Наранчимэг, Л. (2011). *Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний онол арга зүйн асуудал*. Улаанбаатар.
- Отгонцэцэг, Д. (2008). *Санхүү эдийн засгийн шинжилгээ*. Эрдэнэт.
- Сайнжаргал, Б. (1999). *Санхүүгийн тайлангийн шинжилгээ*. Улаанбаатар.
- Сангийн Яам (2022). *Даатгалын байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, журам*. Улаанбаатар хот.
- Скоринкина, П. С. (2006). *Методы формирования схем финансирования инвестиционных проектов на предприятиях*. Санкт-Петербург.
- Сысоева, Е. Ф. (2008). *Финансовые ресурсы и капитал организаций: Сущность, воспроизводство, управление*. Волгоград.
- Тютюкиной, Е. Б. (2014). *Инвестиции и инновации в реальном секторе Российской экономики: Состояние и перспективы*. Москва.
- Фомин, П. А. (2004). *Методология формирования и планирования финансового потенциала предприятия в рамках стратегии экономического роста*. Москва.